



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/64

Булган сум

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн “Лингафон танхим”-ийг хүлээж авахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сансарын нисгэгч Ж.Гүррагчаагийн нэрэмжит Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн “Лингафон танхим”-ийг хүлээж авах ажлын хэсэгт шатахууны зардлыг олгосугай.

2. Ажлын хэсэгт шаардлагатай 1,282,680 (нэг сая хоёр зуун наян хоёр мянга зургаан зуун ная) төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын “Англи хэлтэй Булган” хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
12 дугаар сарын 09-ны/ний өдрийн
А.А.А. дугаар захирамжийн хавсралт



Булган аймгийн Гурванбулаг сум явах тооцоо

д/д	Зардлын төрөл	Машины улсын дугаар	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	2	3	4	5	6	7
1	Дизель түлш (Булган сум – Гурванбулаг сум) (Гурванбулаг сум–Булган сум) нийт 300км	01-26 БУН	л	76	3330	253,080
2	Евро дизель түлш (Булган сум-Гурванбулаг сум- Улаанбаатар хот-Булган сум)	00-01 БУА	л	260	3960	1,029,600
	Дүн					1,282,680